

МОНГОЛ-СИНГАПУРЫН ХАРИЛЦАА

*Б.Хулан**

Сингапур улс нь Зүүн өмнөд Азийн бүс нутаг буюу Малайз, Индонез хоёр улсын хооронд 692.7 хав.км газар нутагтай, 4 сая 425.720 хүн амьдардаг. /2005 оны 7 сарын байдлаар/

Сингапур улс 1819 оноос эхлээд 100 гаруй жил Их Британи улсын колоничлолд байсан ба 1963 онд тусгаар тогносон улс болжээ. Үүнээс хойш 7 жилийн дараа буюу 1970 оны 6 сарын 11-ий өдөр БНМАУ нь Сингапур улсын тусгаар тогнолыг хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоосон байна.

Сингапур улсын хүн амын 76.8% хятад, 13.9% малайз, 7.9% энэтхэг, 1.4% нь бусад үндэснтээс хамаарна. Гол зонхилох шашин шүтлэг нь буддын болон лалын шашин юм. Албан ёсны хэл нь хятад, англи.

Сингапур улс нь парламентийн засаглалтай. Үүнд: Ардын дэвшилтэт нам голлох байр суурь эзэлдэг ба Бүгд найрамдах нам нь 84 суудалтай.

Сингапур улс төрөл бүрийн машин, үйлдвэрийн тоног төхөөрөмж, цахилгаан бараа өргөн хэрэглээний, химийн бараа болон газрын тосны бүтээгдэхүүн зэргийг экспортоор гаргадаг. Хөдөө аж ахуйн салбарын тухайд жимс ногоо, каучук, шувууны аж ахуй, загас агнуур эрхэлдэг. Аж үйлдвэр нь цахилгаан бараа, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл химийн үйлдвэр, эрэг орчмын барилга байгууламж хөгжсөн байна.

Экспортын түнш нь Хонконг, импортын түнш улс нь Малайз, АНУ, Хятад, Япон, Тайвань, Өмнөд Солонгос, Тайланд зэрэг улс орнууд юм.

1963 онд Сингапур улс нь тусгаар тогнолоо олж байх тэр жилүүдэд тус улсад загасчны овоохойноос өөр барилга байгууламж гэхээр юмгүй туйлын дорой буурай хөгжилтэй улс байсан бол 1990 оны эхэн үед Азийн 4 бар хэмээгдэн хөгжлийн өндөр улс түвшинд хүрсэн улс болон хөгжсөн. Ийм асар богино хугацаанд дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудын түвшинд хүрч хөгжсөн туршлага нь манай Монгол шиг шинээр зах зээлийн эдийн засагт шилжиж байгаа дорой буурай хөгжилтэй улс оронд туйлын чухал юм. Манай улсад Сингапур улсын шууд хөрөнгө оруулалт 2003 оны 9.151 мянган ам.доллар байна.

1973 онд Монгол Улсын Гадаад хэргийн яамны төлөөлөгчид Сингапурт айлчилсан аж. Мөн 1976 онд манай Элчин сайд Сингапурт Итгэмжлэх жуух бичгээ барьсныг эс тооцвол хоёр орон 1990 он хүртэл үндсэндээ ямар нэг харилцаагүй явж иржээ. Харин манай оронд өрнөсөн ардчилсан өөрчлөлт шинэчлэлийн үйл явцаас хойш хоёр орны харилцаа идэвхжих хандлагатай болсон билээ. Сингапураас Монгол Улсад суух анхны элчин сайд П.Э.Фонг 1995 оны 5 дугаар сард ирж Итгэмжлэх жуух бичгээ барьсан байна.

* Б.Хулан - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

1990 оны 6 дугаар сард Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга Б.Шаравсамбуу тэргүүтэй Засгийн газрын төлөөлөгчид Сингапурт анх удаа айлчилан Сингапурын үйлдвэрийн сайд, сангийн сайд болон эдийн засгийн бусад байгууллага, пүүс компанийн төлөөлөгчидтэй уулзаж ярилцахад Сингапурын засгийн газар манай орны өөрчлөлт шинэчлэлийг дэмжиж байгаа, хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бэлэн байна гэдгээ илэрхийлсэн байна.

Манай улс хоёр орны хооронд худалдаа, эдийн засгийн харилцаа хөгжүүлэхэд анхаарч 1992 онд худалдаа, эдийн засгийн төлөөлөгчийн газрыг Сингапурт байгуулсан. Монгол Улсын Засгийн газар 2002 онд худалдааны төлөөлөгчийн газрын статусыг дээшлүүлж, Ерөнхий консулын газар болгон өргөтгөсөн бөгөөд 2002 оны 10 дугаар сарын 11-нд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярын Сингапур улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр ерөнхий консулын газрын нээлт болжээ.

1993 онд Дэд бүтцийн сайд Р.Сандаалхан Сингапурт айлчлах үеэр агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурав. Мөн тэр жилдээ хоёр талын засгийн газрын болон хувийн хэвшлийн байгууллагууд хамтран “Монгол, Сингапурын эдийн засгийн хамтын ажиллагааны семинар”-ыг Сингапурт зохион байгуулсан байна.

Хоёр орны их дээд сургуулийн хооронд ч харилцаа тогтоож, багш, оюутан харилцан солилцож байгаа. 1993 онд Сингапурын Политехникийн их сургуулийн багш, оюутнууд ирж манай техникийн их сургуульд компьютерийн лабораторийг байгуулж өгсөн юм.

Манай тал Сингапур улстай хоёр талын хамтын ажиллагаагаа хөгжүүлэхийн зэрэгцээ АПЕК-т элсэх, АСЕАН-ны бүс нутгийн чуулгын хүрээнд хамтран ажиллах чиглэлээр ажиллаж ирэв.

Гадаад харилцааны дэд сайд Ж.Чойнхор 1994 онд Ерөнхий сайдын бие төлөөлөгчөөр Сингапурт айлчлахдаа “Хөрөнгө оруулалтыг хөгжүүлэн дэмжих, хамгаалах тухай” хэлэлцээрийг үзэглэсэн байна. Энэхүү айлчлалын үеэр хоёр орны иргэдийг хоёр долоо хоногийн хугацаанд харилцан визгүй зорчуулж байхаар тохиролцож улмаар 1995 оны Ерөнхий сайд П.Жасрай айлчлалын үеэрээ уг Хэлэлцээрт гарын үсэг зурсан байна.

Нью-Йорк хотноо НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 51 дүгээр чуулганд оролцох үеэрээ ерөнхий сайд М.Энхсайхан Сингапурын гадаад хэргийн сайд Жаяакумартай уулзсан байна. Уг уулзалтын үеэр Сингапурын тал НҮБ-ын Аюулгүй Зөвлөлд 2001-2002 онд байнгын гишүүнээр сонгогдон ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлж дэмжлэг хүссэнийг манай тал дэмжсэн бөгөөд Сингапур улс сонгогдсон байна. 2000 онд Нью-Йорк хотноо хоёр улсын төр засгийн төлөөлөгчид хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцсон билээ.

2001 оны Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Сингапур улсад хийсэн айлчлал нь хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг

шинэ зуунд гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чухал алхам болсон юм. Айлчлалын үеэр Монгол Улс болон Сингапур улсын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн хооронд хамтран ажиллах асуудлаар харилцан ойлголцох Санамж бичигт гарын үсэг зурсан билээ.

2002 онд Батлан хамгаалахын дэд сайд Ц.Тогоо Сингапур улсад ажлын айлчлал хийж хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцааг бодит үйл ажиллагаа болгон хэрэгжүүлэхэд тохиролцжээ.

Монгол Улсын ерөнхий сайд Н.Энхбаяр 2002 онд Сингапур улсад албан ёсны айлчлал хийв. Уг айлчлалын үеэр Сингапураас Монголд хөрөнгө оруулах пүүс, компаниудаа Сингапурын Засгийн газар дэмжихээ илэрхийлж, олон салбарын чиглэлээр Сингапурын техникийн хамтын ажиллагааны хөтөлбөрт Монголоос хамрагсдын тоог нэмэгдүүлэхээ амласан байна. Мөн давхар татвараас харилцан чөлөөлөх тухай Монгол, Сингапурын засгийн газар хоорондын Хэлэлцээрт гарын үсэг зурж, Худалдаа аж үйлдвэрийн танхим хоорондын хамтын ажиллагааны гэрээ байгуулжээ.

Манай улс Сингапураас хөргөх, хөлдөөх цахилгаан буюу цахилгаан бус төхөөрөмжүүд, ахуйн цахилгаан хэрэгсэл, мэдээлэл боловсруулалтын автомат төхөөрөмж, тэдгээрийн бүрдэл хэсгийг импортлож, харин Сингапур руу алт экспортлодог юм. Хоёр улсын хооронд МИАТ компани 1994 оноос захиалгат нислэг хийж эхэлсэн байна.

2005 онд Монгол Улсын ерөнхий сайд Ц.Элбэгдорж Сингапур улсад айлчлахдаа хоёр орны харилцааг мэдээллийн технологи, боловсрол, хөрөнгө оруулалт, барилга хот байгуулалт, аялал жуучлалын салбарт өргөн хүрээтэй хамтран ажиллах талаар санал солилцов. Энэ үеэрээ НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын бус гишүүний сонгуульд Монгол Улс нэрээ дэвшүүлэх, АПЕК, АСЕМ зэрэг бүс нутгийн олон талт үйл ажиллагаанд нэгдэх Монгол Улсын хүчин чармайлтад Зүүн Өмнөд Азийн нөлөө бүхий орны хувьд дэмжлэг үзүүлэхийг хүсчээ.

Монгол Улсын төлөөлөгчид Сингапурын их сургуулийн Зүүн Азийн институт, мэдээлэл, харилцаа холбооны газар, эдийн засгийн хөгжлийн газар, Сингапурын бодлого судлалын төв зэрэг тус улсын төдийгүй дэлхийд нэр бүхий судалгааны төвүүдээр зочилж, эрдэмтэд судлаачидтай уулзаж, харилцан сонирхсон асуудлаар санал солилцсон байна.

Цаашид манай улс Сингапур улстай урт удаан хугацаагаар найрсаг харилцаа тогтоож хөгжинө гэдэгт найдаж байна. Мөн аялал жуулчлал хөгжиж байгаа өнөө үед гадаад, дотоодын зочид төлөөлөгчид ихээр очиж үзэж байгаа болон Монголоос тус улсад оюутан залуус ч нэлээд хэмжээгээр суралцаж байна.

Ашигласан эх сурвалж

1. ГХЯ-ын website
2. ГХЯ-ын архиваас
3. /Zuun- Europe/ CIA- The World factbook-Singapore.htm